



**МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ**

2009 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 507

Улаанбаатар хот

Г Гадаадад сургалтын төрийн сангийн  
зээлээр суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” 177 тоот тогтоолоор баталсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар баталсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. 2009-2010 оны хичээлийн жилээс Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар Туваансүрэнгийн Хишгээг Америкийн Нэгдэн Улсын Канзас хотын Паркийн их сургуулийн сургалтын төлбөрийн 50 хувийн тэтгэлэгтэйгээр бакалаврын сургалтанд санхүүгийн удирдлагын чиглэлээр 4 жилийн хугацаатай Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

2. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж жиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.



*Handwritten signature in blue ink*

Ё.ОТГОНБАЯР